



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 06 дугаар
сарын 03 ны өдөр

Дугаар 1971/1568

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Л.ЭНХБОЛД ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутаг дэвсгэрт орших Тост, тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоосон асуудлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

0006802

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.ЭНХБОЛДООС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. “Сауд гоби коэл транс” ХХК-д MV-017038, MV-019036 тусгай зөвшөөрлүүдийг олгохдоо тухай нутаг орны иргэдийн саналыг авсан эсэх талаар:

Хариулт. Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгохдоо тухайн нутаг орны иргэдийн саналыг авах талаар хуульчилсан зохицуулалт байхгүй. Ашигт малтмалын тухай хуулийн 24.1-т “Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн уг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах эрхтэй.” гэж заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийнхөө талбайд хайгуулын ажил явуулж нөөц тогтоон улсын бүртгэлд бүртгүүлсэн байдал, тусгай зөвшөөрөл эзэмших үүргээ биелүүлж байсан гэсэн тодорхойлолт зэргийг үндэслэн ашиглалтын тусгай зөвшөөрлийг давуу эрхээр олгодог.

Харин “Сауд гоби коэл транс” ХХК-д хайгуулын тусгай зөвшөөрлийг тухайн үед олгохдоо Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн бол төрийн захиргааны байгууллага нь энэ талаар тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх бөгөөд түүнд энэ хуулийн 17.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зургийг хавсаргана.” гэж, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ” гэж тус тус хуульчилсаны дагуу Өмнөговь аймгийн Засаг даргаас санал авч байсан. Энэ зүйлийг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон болно/

Түүнчлэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна” гэж, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.4-д “Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна” гэж орон нутгийн иргэдийн оролцоог хангахаар тус тус хуульчилсан байдаг.

Асуулга 1.1. “Сауд гоби коэл транс” ХХК-д MV-017038, MV-019036 тусгай зөвшөөрлүүд нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль болон бусад эрх зүйн хүрээнд олгогдсон эсэх талаар:

Хариулт. MV-017038 ашиглалтын тусгай зөвшөөрлийн тухайд: “Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт орших 11187Х хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд орших Баянтэсийн чулуун нүүрсний ордод 2005-2012 онд хийсэн хайгуулын ажлын тайлан”-г (2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн нөөц) Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн

ХХ-07-01 хуралдаанаар хэлэлцэж дүгнэлт гаргасан байна. Уг дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмалын газрын даргын 2012 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 223 дугаар тушаалаар “Сауд гоби коэл транс” ХХК-ийн нөөцийг хүлээн авч Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн.

Уг тайлангийн Гашуу толгойн хэсгийн эдийн засгийн үр ашигтай баттай (А) зэргийн нөөцийг 21.51 сая.тн-оор, бодитой (В) зэргийн нөөцийг 11.81 сая.тонноор, боломжтой (С) зэргийн нөөцийг 24.87 сая.тн-оор, баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэргийн нөөцийг 58.19 сая.тонноор, Хөвд хэсгийн эдийн засгийн үр ашигтай бодитой (В) зэргийн нөөцийг 6.75 сая.тонноор, Гашуу толгойн тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай баттай (А) зэргийн нөөцийг 7.79 сая.тонноор, бодитой (В) зэргийн нөөцийг 19.39 сая.тонноор, боломжтой (С) зэргийн нөөцийг 59.66 сая.тн-оор, баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэргийн нөөцийг 86.84 сая.тонноор, Хөвд хэсгийн тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай бодитой (В) зэргийн нөөцийг 17.97 сая.тонноор, боломжтой (С) зэргийн нөөцийг 7.35 сая.тн-оор, бодитой болон боломжтой (В+С) зэргийн нөөцийг 25.33 сая.тонноор, Хуршуут хэсгийн тодорхой нөхцөлд эдийн засгийн үр ашигтай боломжтой (С) зэргийн нөөцийг 4.997 сая.тонноор нүүрсний нөөцийг хүлээн авахаар шийдвэрлэжээ.

“Сауд гоби коэл транс” ХХК-ийн зүгээс хайгуулын үр дүнгээр тогтоогдсон нөөцөө улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлөө 2012 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтэст ирүүлж, кадастрын өргөдлийн бүртгэлийн NM-025243 дугаарт бүртгүүлсэн байна.

Өргөдлийг хянахад өргөдөл түүнд хавсаргасан материал хуулийн шаардлага хангасан гэж үзээд Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.2 дахь заалтыг үндэслэн Ашигт малтмалын газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 345 дугаар шийдвэрээр Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Баянтэс нэртэй 372221.42 Га талбай бүхий ашигт малтмалын МУ-017038 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Сауд гоби коэл транс” ХХК-д олгосон байна.

“Сауд гоби коэл транс” ХХК нь ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлдөө дараах материалыг Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлсэн. Үүнд:

- Хуулийн этгээдийн тодорхойлолт;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Хан-Уул дүүргийн татварын хэлтсийн тодорхойлолт;
- “Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших 11187Х хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд орших Баянтэсийн чулуун нүүрсний ордод 2005-2012 онуудад хийсэн хайгуулын ажлын тайлан”-г Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн ХХ-07-01 хуралдаанаар хэлэлцсэн тухай дүгнэлт;
- Ашигт малтмалын газрын даргын 2012 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн ““Сауд гоби коэл транс” ХХК-ийн нөөцийг хүлээн авч, Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тухай” 223 дугаар тушаал;
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2012 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хуулийн дагуу үнэлгээ хийсэн тухай” 6/1790 албан бичиг;

- Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг даргын 2012 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн "Хайгуулын талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулах хугацаандаа техникийн нөхөн сэргээлтийг зохих түвшинд хийж Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох журмын дагуу ажилласан тухай" 1/114 албан бичиг;
- Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд 2011, 2012 онд хийсэн Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын мэдээ;
- Ашигт малтмалын газраас Усны газар, Ойн газар, Авлигатай тэмцэх газарт "Сауд гоби коэл транс" ХХК-д ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох тухай" тодруулга хүссэн албан бичиг зэрэг болно.

MV-019036 ашиглалтын тусгай зөвшөөрлийн тухайд: Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших XV-11187 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд орших Баянтэсийн чулуун нүүрсний ордын Хүрэнцавын хэсэгт 2006-2014 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, Гашуу толгойн хэсгийн нөөцийн тодотголыг (ордын нөөц 2014 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар) Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн ХХ-12-21 хуралдаанаар хэлэлцэж дүгнэлт гаргасан байна. Уг дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмалын газрын даргын 2012 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 223 дугаар тушаалаар "Сауд гоби коэл транс" ХХК-ийн нөөцийг хүлээн авч, Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн.

Уг тайлангийн Гашуу толгой-1 нэртэй XV-011187 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах Баянтэсийн чулуун нүүрсний ордын Гашуу толгой, Хүрэн цавын хэсэгт нийт баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэргийн цэвэр нүүрсний нөөцийг 53,480,540.0 тонноор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 54,477,347.2 тонноор үүнээс Хүрэн цавын хэсэгт бодитой болон боломжтой (В+С) зэргийн цэвэр нүүрсний нөөцийг 23,605,378.2 тонноор, чулууны үетэй нүүрсний нөөцийг 24,100,529.1 тонноор, Гашуу толгойн хэсэгт баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэргийн цэвэр нүүрсний нөөцийг 29,875,161.8 тонноор, чулууны үетэй нүүрсний нөцийг 30,376,818.1 тонноор тус тус шинжээчийн зөвшөөрснөөр, зохиогчдын тооцоолсон хувилбараар хүлээн авч, Гашуу толгой-1 нэртэй XV-011187 тоот тусгай зөвшөөрлийн талбайн Баянтэсийн чулуун нүүрсний ордын Гашуу толгойн хэсэгт хамаарагдах баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэргийн цэвэр нүүрсний нөөцөөс 29,875,161 тонноор, чулууны үетэй нүүрсний нөөцөөс 30,376,818.1 тонныг хасч нөөцийн хөдөлгөөн хийхийг Геологийн мэдээллийн төв архивт зөвшөөрөх талаар тусгасан байна.

"Сауд гоби коэл транс" ХХК нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг Гашуу толгой 1 нэртэй 12380.72 гектар талбайд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг 2014 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр гаргаж кадастрын өргөдлийн бүртгэлийн NM-025500 дугаарт бүртгүүлсэн болно.

Өргөдлийг хянахад өргөдөл түүнд хавсаргасан материал хуулийн шаардлага хангасан гэж үзээд Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.2 дахь заалтыг үндэслэн Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн даргын 2015 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 653 дугаар шийдвэрээр Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Гашуу толгой-1 нэртэй 12380.72 га талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмалын МҮ-019036 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Сауд гоби коэл транс" ХХК-д олгосон.

“Сауд гоби коэл транс” ХХК нь ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд дараах материалыг Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлсэн. Үүнд:

- Хуулийн этгээдийн тодорхойлолт;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- Хан-Уул дүүргийн татварын хэлтсийн тодорхойлолт;
- “Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших XV-11187 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд орших Баянтэсийн чулуун нүүрсний ордын Хүрэнцавын хэсэгт 2006-2014 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, Гашуу толгойн хэсгийн нөөцийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн ХХ-12-21 хуралдаанаар хэлэлцсэн дүгнэлт;
- Ашигт малтмалын газрын даргын 2014 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн ““Сауд гоби коэл транс” ХХК-ийн нөөцийг хүлээн авч, Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэсэн тухай” к-136 дугаар тушаал;
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны 2014 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргасан тухай “6/5158 тоот албан бичиг;
- Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Засаг даргын 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Хайгуулын талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулах хугацаандаа Байгаль орчны нөхөн сэргээлтийг тухай бүрд гүйцэтгэж байсан тухай” 1/291 тоот албан бичиг зэрэг болно.

Асуулга 1.2. “Сауд гоби коэл транс” ХХК нь тусгай зөвшөөрөл эзэмших хугацаандаа Байгаль орчны нарийвчилсан менежментийн төлөвлөгөөг батлуулсан эсэх талаар:

Хариулт. “Сауд гоби коэл транс” ХХК-ийн MV-017038, MV-019036 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь Засгийн газрын 2012 оны 194, 2015 оны 289-р тогтоолоор батлагдсан гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, улсын тусгай хамгаалалттай газар нутагтай тус тус давхцалгүй байна.

“Сауд гоби коэл транс” ХХК-ийн Баянтэсийн чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2017-2021 онд хэрэгжих Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамт батлагдсан байна.

Асуулга 2. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин ба хүний нийгэмд нөлөөллийг Монгол Улсын хууль, олон улсын байгаль орчин ба хүний эрхийн гэрээ конвенцийн эрх зүйн норм, стандартад нийцүүлж байгаа эсэхэд хяналт тавьж буй эсэх талаар; зөрчлийг арилгуулах арга хэмжээ, эрх нь хөндөгдсөн талуудын эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлж буй эсэх талаар:

Хариулт. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ” гэж заасны дагуу МХЕГ, Өмнөговь аймгийн МХГ тухайн “Сауд гоби коэл транс” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг. “Сауд гоби коэл транс” ХХК-ийн үйл ажиллагаанаас шалтгаалан хүний эрх зөрчигдсөн, байгаль орчныг сөрөг нөлөөлөл үүссэн талаар мэдээлэл ирүүлээгүй байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь хэсэгт “ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээнд авах зорилгоор төрийн мэдэлд шилжүүлэн авч нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбай болон энэ хуулийн 26.9-д заасан талбайгаас тусгай зөвшөөрөл олгож болно” хэмээн хуульчилсан байдаг.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 90, 91 дүгээр тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Ноён уул орчмын байгалийн нөөц газрын хилийн зааг, Төв аймгийн Борнуур, Батсүмбэр сумдын нутагт орших Ноён уул орчмын дурсгалт газрын хилийн зааг, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоосонтой холбогдуулан дээрх газар нутагт тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуйн нэгжүүд АМТХуулинд заасны дагуу хэлцэл хийх замаар нөхөх олговрын зориулалтаар шинээр тусгай зөвшөөрөл олгож өгөхийг хүссэн хүсэлтээ УУХҮЯаманд гаргаж шийдвэрлүүлсэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/110 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг дээрх асуудлыг судалж “тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр шинээр тусгай зөвшөөрөл олгох боломжтой” гэсэн дүгнэлт гаргасан.

Улмаар Монгол улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 256 дугаар тогтоолоор Булган аймгийн Тэшиг сумын нутагт орших дархан цаазат газрын хилийн зааг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Ноён уул орчмын байгалийн нөөц газрын хилийн зааг, Төв аймгийн Борнуур, Батсүмбэр сумдын нутагт орших Ноён уул орчмын дурсгалт газрын хилийн зааг, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн заагтай давхцалтай тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр нөхөх олговрын зориулалтаар тусгай зөвшөөрөл шинээр олгох талбайн солбицлыг баталж, хилийн заагтай давхцалтай тусгай зөвшөөрлүүдийг цуцлахыг даалгасан байдаг.

Уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн а/174 дүгээр тушаал гарч, Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 559 дүгээр шийдвэрээр нөхөх олговрын зориулалтаар дараах тусгай зөвшөөрлүүдийг шинээр олгож (хүснэгт-2), 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 560 дугаар шийдвэрээр хилийн заагтай давхцалтай тусгай зөвшөөрлүүдийг цуцалж (хүснэгт-1) шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 1

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	MV-013927	2008.07.25	Булган	Тэшиг	Цагаан жалга	Азаргын гол чонот ХХК

2	XV-013490	2008.04.07	Булган	Тэшиг, Сэлэнгэ	Хөх чулуутын ам	Азаргын гол чонот ХХК
3	XV-012614	2007.08.03	Сэлэнгэ	Мандал	Сэл	Билүүт-Эрдэс ХХК
4	MV-016664	2010.09.27	Сэлэнгэ	Мандал	Сэл	Сэлмандал ХХК
5	XV-012472	2007.05.29	Өмнөговь	Гурвантэс	Дэлийн хяр	Эф Эм Ай ХХК
6	XV-013109	2007.12.26	Өмнөговь	Гурвантэс	Шаван уул	Мөнхийн номхон далай ХХК
7	XV-013108	2007.12.26	Өмнөговь	Гурвантэс	Тост-1	Намуунтод ХХК
8	XV-013107	2007.12.26	Өмнөговь	Гурвантэс	Дэрст толгой	Намуунтод ХХК
9	XV-014145	2008.09.10	Өмнөговь	Гурвантэс	Улаан сайр	Элбэг-Орд ХХК

/Азаргын гол чонот ХХК-ийн XV-0139268 XV-012443 тоот хайгуулын тусгай зөвшөөрлүүд нь хүчин төгөлдөр байх хугацаа дууссан хүчин төгөлдөр бус байсан/

Хүснэгт 2

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Талбай байрших аймаг, хот	Талбай байрших сум, дүүрэг	Талбай н хэмжээ /гектар /	Олгосон тусгай зөвшөөрөл
1	"Билүүт эрдэс" ХХК	Төв	Баян	1495.08	XV-020925
2	"Билүүт эрдэс" ХХК	Хэнтий	Хэрлэн	214.51	XV-020926
3	"Сэл мандал" ХХК	Төв	Баян	772.92	XV-020924
4	"Намуун тод" ХХК	Сүхбаатар	Эрдэнэцагаан	1252.14	XV-020932
5	"Намуун тод" ХХК	Сүхбаатар	Эрдэнэцагаан	3892.35	XV-020933
6	"Эф Эм Ай" ХХК	Өмнөговь	Цогт-Овоо, Цогтцэций	588.87	XV-020937
7	"Мөнхийн номхон далай" ХХК	Төв	Лүн, Баянхангай	7104.18	XV-020911
8	"Мөнхийн номхон далай" ХХК	Баянхонгор	Бөмбөгөр	1128.98	XV-020910
9	"Элбэг орд" ХХК	Өмнөговь	Хүрмэн	7864.94	XV-020923
10	"Элбэг орд" ХХК	Өмнөговь	Гурвантэс	1463.82	XV-020922
11	"Азаргын гол чонот" ХХК	Өмнөговь	Хүрмэн	14034.94	XV-020918
12	"Азаргын гол чонот" ХХК	Дорнод	Дашбалбар	5929.95	XV-020917
13	"Азаргын гол чонот" ХХК	Өвөрхангай	Хайрхандулаан, Баруунбаян, Гучин-Ус	7957.91	XV-020916
14	"Азаргын гол чонот" ХХК	Сүхбаатар	Эрдэнэцагаан	880.8	XV-020914
15	"Азаргын гол чонот" ХХК	Сүхбаатар	Эрдэнэцагаан	7696.98	XV-020919

16	“Азаргын гол чонот” ХХК	Өмнөговь	Гурвантэс	2883.34	XV-020915
17	“Азаргын гол чонот” ХХК	Өмнөговь	Ханхонгор, Цогт-Овоо, Цогтцэций	8981.96	XV-020913
18	“Азаргын гол чонот” ХХК	Ховд	Алтай	996.42	XV-020912

Асуулга 3. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг, Үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3.4 дэх заалтыг үндэслэн Байгаль орчны тэнцвэрт байдал, байгалийн унаган төрх, түүх, соёлын үнэт өвийг тогтвортой хадгалах, устгах аюулд орсон амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд онцгой ач холбогдол бүхий Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших Тост, Тосон бумбын нурууг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч, хилийн заагийг 889000 га хэмжээтэй байхаар Улсын Их Хурлын 35 дугаар тогтоолыг 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр баталсан. Гэвч 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 91 дүгээр тогтоолоор Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн заагийг 743058 га болгон өөрчилсөн нь Улсын Их Хурлын 35 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж буй эсэх талаар:

Хариулт. Монгол оронд төдийгүй дэлхийд ховордож, улаан дансанд орсон цоохор ирвэсийн өндөр нягтшилтай идээшин амьдардаг цөөн нутгийн нэг болох Тост, Тосон бумбын нурууг Монгол Улсын Их Хурлын 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 35 дугаар тогтоолоор байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан.

Хилийн заагийг тогтоохдоо Шинжлэх ухааны академийн Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн шинжлэх ухааны доктор Б.Оюунгэрэл, “Ирвэс хамгаалах сан” ТББ-ын судлаачидтай хамтран хийж гүйцэтгэсэн суурь судалгаа, үндэслэл боловсруулах судалгаагаар 618916.02 га, Де Нэйчэ Консерванси олон улсын байгууллагаас доктор Ю.Баяржаргал, шинжлэх ухааны доктор Б.Оюунгэрэл, судлаач Г.Цогтжаргал, Г.Мөнхзул, Б.Цогтбаатар, Г.Пүрэвбаатар нарын хийсэн хамгаалалтад авах зайлшгүй шаардлагатай, экологийн хувьд чухал ач холбогдолтой газрын судалгаагаар 693257.5 га, Гурван тэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Улсын улсын тусгай хамгаалалтад авах тухай” 21 дугаар тогтоолоор 66891 га-аар, Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” 66 дугаар тогтоолоор Тост, Тосон бумбын нуруу орчмын 568191 га талбайг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгалалтад авах зэргийг үндэслэсэн.

Мөн ирвэсийн тархалт нутгийн нөлөөллийн бүсэд хамаарахгүй болон Ашигт малтмал, Газрын тосны газарт 2016 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 03/900 тоотоор хилийн заагтай хэсэгчилэн болон бүрэн давхцалтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын 10 тусгай зөвшөөрлийн нөхөх олговрыг тооцуулахаар хүргүүлсний дагуу 2016 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 1/168 тоотоор ирүүлсэн тусгай зөвшөөрлүүдийн нийт зардал 14 тэрбум төгрөг, үүнээс геологи хайгуулын ажлын зардал 13 тэрбум төгрөг, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 960 төгрөгийн зардлын хэмжээнээс шалтгаалан MV-170388, MV-19036, XV-14398 ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүдийн хасч тогтоосон байдаг.

Эдгээр санал, судалгааг үндэслэн байгалийн нөөц газрын хилийн заагийг 743058.00 га талбайгаар Монгол Улсын Их Хурлын 2016 оны 04 дүгээр сарын 14-ний

өдрийн 35 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт "Байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч байгаа газар нутгийн хилийн заагийг тогтоохыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай", Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6-д "Байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох" гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 91 дүгээр тогтоолоор тогтоосон.

oOo